

**“АТАР ӨРГӨӨ” ХК-Н ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

№ 24/01

Улаанбаатар хот

“Атар Өргөө” ХК-н хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурал 14.00 цагт Тооллогын комиссын бүртгэл, ирцийн мэдээгээр 94,31% буюу нийт 164,223 ширхэг хувьцаатай 25 хувьцаа эзэмшигч хуралд оролцлоо. Үүнээс саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй байна.

Хуралд биечлэн оролцож байгаа 20 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр, 5 хувьцаа эзэмшигч итгэмжлэлээр, нийт 25 хувьцаа эзэмшигч, ажиглагчаар СЗХ-ноос 3 байцаагч бүртгүүлснээр хурлын үйл ажиллагаа эхлэв.

Итгэмжлэлээр:

1. Бэрэн групп ХХК-ийн эзэмшдэг 69,654 ширхэг хувьцааг төлөөлж, Б.Мөнхдалай
2. Н.Паламдоржийн эзэмшдэг 8,045 ширхэг хувьцааг төлөөлж, Б.Ганбат
3. А.Баттулгын эзэмшдэг 27,424 ширхэг хувьцааг төлөөлж, А.Баярсайхан
4. Таванбогд инвест ХХК-ийн 9,157 ширхэг хувьцааг төлөөлж, З.Төрболд
5. С.Адьяасүрэнгийн эзэмшдэг 39,181 ширхэг хувьцааг төлөөлж, Ц.Алтанцэцэг

Ажиглагчаар:

1. СЗХорооны Компанийн засаглал, комплайнсын хэлтсийн дарга, улсын байцаагч А.Авир,
2. СЗХорооны Хууль эрх зүйн референт, улсын байцаагч Р.Цэвэлмаа
3. СЗХорооны ХШЗГ-ын ахлах хянан шалгагч Ц.Энхжаргал

тус тус оролцлоо.

Хурлын дарга Б.Мөнхдалай: - Хурлын дарга Б.Мөнхдалай хурлыг нээж, хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

ХЭЭХурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт,
2. Ноогдол ашиг хувиарлах эсэх,
3. Компанийн 2023 оны бизнес, үйл ажиллагааны тайлан
4. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө
5. ТУЗ-ын дарга болон ТУЗ –ийн гишүүдийг сонгох.
6. ТУЗ-ын дарга болон ТУЗ –ийн гишүүдийн урамшууллын хэмжээг тогтоох.

С.Адьяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Алтанцэцэг: -ХЭЭХурлын хэлэлцэх асуудлаар санал өгөх эрхтэй эсэх талаар тодорхой хариулт өгнө үү. Өнгөрсөн жилийн хуралд оролцуулаагүй тухай дахин дурьдав.

А.Баттулгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Баярсайхан: Өнгөрсөн жилийн хуралд СЗХ-ны ХШЗГ-ын даргын бичигтэй ирээл ХЭЭХуралд оролцоогүй, өнөөдөрийн хуралд санал өгөх эрхтэй юу гэж асууллаа.

Санхүүгийн албаны дарга Отгондулам: Борлуулалт төлөвлөгөөндөө хүрээгүй учир нэмэлт байхгүйг хэлэв.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг хуваарилахгүй талаар хэлэлцэх бол Хувьцаа эзэмшигч нар хуралд оролцох шаардлагатай юу гэж асуув.

ТУЗ-н Хараат бус гишүүн Бямбахорол:

- 2023 оны аудитын тайланг танилцуулахдаа аудитын хязгаарлагдмал тайлан гаргасан байна. Борлуулалт өнгөрсөн оноос буурсан. Өөрийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, Хөдөлмөр аюулгүй байдал /ХАБ/-аа сайжруулсан. Ажилчдыг ажлын байрыг хангаж, цалин хөдөлмөрийн хөлсыг нэмэгдүүлж, ажилласан.

Цэвэр ашгаас НА-г хуваарилах талаар ХЭЭХ-р хэлэлцэж, батална. Учир нь өнгөрсөн жилийн ХЭЭХурлыг СЗХ-ноос хүчингүй болгосонтой холбоотойгоор энэ тал дээр шийдвэр гаргаж чадаагүй болно.

Аудитын тайлан ХЭЭХурлын материал тараахаас өмнө гарч амжаагүй. Бид хурлын материалд аудитын компаниас хугацаандаа гаргаж, өгөөгүй талаар тайлбар албан бичиг авсаныг хавсаргасан байгаа.

ХЭЭХ-аас өмнө хараат бус аудитын дүгнэлт гарсаныг Та бүхэнд танилцуулж байна. Жилийн эцсийн тайланг хугацаанд нь СЗХ болон МХБ-д хүргүүлсэн бөгөөд аудитын тайланг ч СЗХ болон МХБ -д хүргүүлнэ.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Авлагаа тайлбарлаж өгнө үү.

Эдийн засагч Гантуул: - Барьцаа, бэлэн авлага, бусад /Бэрэн ХХК/ баримтаар баталгаажуулсан. Бэрэн ХХК-с авах авлага бол толгой компанийн санхүүгийн жилд орсон дараа суутган авдаг.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: - Компани ашиггүй ажиллаж байна. Бэрэн ХХК-д олгосон санхүүжилт хэзээ төлөгдөх талаар мэдэх шаардлагатай байна. Компани нь ХК, ХХК-г тус тусдаа байлгая зээл олгосон бол хүүтэй байх ёстой.

ТУЗ-н гишүүн халаасны хувьцааг анхлан авсан байгаа учир баримт шалгах хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Компанийн барилга байгууламж, газрын талаар мэдээллийн үнэлгээг авъя.

Эдийн засагч Гантуул: Компанийн байгууламж, газар өөрчлөгдөөгүй үнэлгээ 4-5 сард гарна. Үнэлгээний компанид шалгагдаж байна.

Хувьцаа эзэмшигч Нямдорж: Аудит Тайлан нь СЗХ-д хүргүүлэх талаар хоцрогдолтой байна.

Санхүүгийн албаны дарга Отгондулам: Тогтсон хугацаанд тайлангаа хүргүүлсэн, аудитын тайлан хоцорсон шалтгаан нь аудитын компанийн шалгалт, судалгаа удааширсантай холбоотой.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Ноогдол ашиг авмаар байна. Хурлын материал, тайланг өөрөөр гаргаж өгөх хэрэгтэй бусад компанитай харьцуулав. /Говь ХК гэх мэт/

ТАТА

ӨРГ
ХК

3.2023
ХҮҮ

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Бэрэн ХХК 1,3 тэрбумын өртэй гэж байна хэзээ барагдуулах вэ.

Эдийн засагч Гантуул: Хоорондын тооцоогоор хуваарийн дагуу жил жилдээ барагдуулна.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: ТУЗ-н цалин хөлс, урамшуулалаас Та бүхэн татгалзаад хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг хэлбэрээр өгөх боломтой юу.

Хурлын дарга Б.Мөнхдалай: ХЭЭХ-н саналын хуудсаар шийдэгдэх асуудал

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: ХК-н ноогдол ашгийг 100 төгрөгөөр тооцож олгох боломжтой юу, Компани ашиг орлогоо нэмэгдүүлж, ноогдол ашиг олгох хэрэгтэй байна.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Саналын хуудсаар шийдэгдэнэ.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Ноогдол ашгийг авахаар хуралд ирсэн.

С.Адъяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Алтанцэцэг: Бэрэн ХХК-н удирдах албан тушаалтан нь нэг гэр бүлийнх юм байна.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: ХК-нь нийт 104 хувьцаат компаниас 103-т бичигдэж байна Дээшлүүлэх талаар ТУЗ нь ямар шийдвэртэй байгаа вэ, санал өгөхгүй ХЭ-ч яах вэ, мөн бизнес төлөвлөгөөг дэмжихгүй байна.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Саналын хуудсаар бүх зүйл шийдэгдэнэ.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Саналын хуудсаар жижиг ХЭ-чийн санал шийдэгдэх магадлал бага үүнд ямар санаа тавьж байна. СЗХ энэ тал дээр арга хэмжээ авах, хууль санаачлах боломжтой юу, тайлан сайн биш байна.

Хувьцаа эзэмшигч З.Төрболд: Өмнөх хурал хүчингүй гэснийг шүүх шийдсэн үү.

СЗХорооны Компанийн засаглал, комплайнсын хэлтсийн дарга, улсын байцаагч А.Авир: СЗХороог төлөөлж 3-н хүн ажиглагчаар оролцож байна. Атар өргөө ХК-н удирдлагад албан бичиг хүргүүлсэн ХЭ-ч нь санал өгөх боломжоор хангахыг хүсэж байна.

С.Адъяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Алтанцэцэг: Хурал зохион байгуулагчаас зөвлөгөө, асуух асуумж байна, мэргэжлийн компани гэж ойлгосон байна.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: ТУЗ-н гишүүдийн танилцуулга хэрэгтэй байна, хувьцааны тоо, хувь гэх мэт

Хурлын дарга Б.Мөнхдалай: Хурлын танилцуулах материалд бүгд байгаа.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Цаашдын төлөвлөгөө, ногдол ашгийн талаар сайн ойлголт өгөх, авлагаа хурдан барагдуулж ашгаа өсгөх, мөн жижиг хувьцаа эзэмшигчдээс ТУЗ-д орох боломжтой юу.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Хувьцааны эзэмшил, саналаар шийдэгдэнэ. Саналын эрхгүй хувьцаа эзэмшигчдийн эрх сэргээгдэж, саналын эрхтэй болох үед саналаа өгч болно. Саналын эрхийн хязгаарласан Дээд шүүхийн 2-ч шийдвэр байгаа.

С.Адъяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Алтанцэцэг: Санал өгөх боломжтой гэж бодож байна.



Хурлын дарга Б.Мөнхдалай: Шүүхийн шийдвэр гарсаны дараа боломжтой болно. Дээд шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрнө.

С.Адьяасүрэнгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Алтанцэцэг: Энэ хурлыг хүчин төгөлдөр гэж үзэхгүй байна. СЗХ санал өгөх эрхтэй гэж шийдвэр гаргасан.

Хурлын дарга Б.Мөнхдалай: Журмаараа явах ёстой маргааныг шүүх шийднэ. 6-н жил ийм байдалтай байна, саналын эрхгүй хувьцааг худалдан авсан учир гомдолоо шүүхээр шийдүүлэх эрхтэй.

Саналын хуудсыг бөглүүлэхээр 16 цаг 30 минут тарааж, саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар тайлбар өгөв.

Тооллогын комисс саналын хуудасыг хураан авч хурал түр завсарлав.

Тооллогын комиссын дарга Л.Гантуяа саналын хуудсын тооллогын дүн болон ТКТогтоол 24/2-ыг 17 цаг 50 минут танилцуулав.

Үүнд:

Санхүүгийн тайлан зөвшөөрсөн 90,37 хувь, татгалзсан 9,62 хувь

Үйл ажиллагааны тайлан зөвшөөрсөн 90,37 хувь, татгалзсан 9,63 хувь

Ногдол ашиг хувиарлахгүй тухай зөвшөөрсөн 90,37 хувь, татгалзсан 9,62 хувь

Үйл ажиллагааны төлөвлөгөө зөвшөөрсөн 90,37 хувь, татгалзсан 9,63 хувь

ТУЗ-д нэр дэвшүүлэх тухай зөвшөөрсөн 90,43 хувь, татгалзсан 9,57 хувь

Ердийн гишүүнд нэр дэвшигч дэвшүүлэх

Хараат бус гишүүнд дэвшүүлэх

ТУЗ –ийн гишүүдийн урамшуулал зөвшөөрсөн 90,42 хувь, татгалзсан 9,58 хувь

Хурлын дарга Б. Мөнхдалай ХЭЭХурлаас гарсан ХЭЭХ-ийн тогтоолуудын уншиж, танилцууллаа.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн санхүүгийн тайлангийн түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт болон ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт болон тайлангуудыг холбогдох цахим хуудсанд тогтмол байршуулах, цаашид компанийн бизнес төлөвлөгөөний дагуу ажиллахыг гүйцэтгэх захирал /Ж.Сайнбилэг/-т даалгасугай.
3. Компани нь 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэнийг зөвшөөрсүгэй.
4. Компанийн ТУЗ болон хараат бус гишүүдийг дараах бүрэлдхүүнтэйгээр сонгосугай:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд:

1. Б.Мөнхдалай
2. Б.Ганбат
3. Ж.Сайнбилэг
4. Г.Баттулга
5. Г.Энхболд
6. Л.Ганпүрэв

ТУЗ-ын хараат бус гишүүдэд:

1. С.Бямбахорлоо
2. Т.Жигмэддагва
3. Г.Оюун

5. ТУЗ-ын болон Хараат бус гишүүдийн 2024 оны урамшууллын дүнг хавсралт 1-ээр баталсугай.

ТУЗ-ын дарга Б.Мөнхдалай хурлыг хааж, үг хэлсэнээр ТУЗ-ын хурал 18.00 цагт өндөрлөв.

Хурлыг удирдсан :

Хурлын дарга

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичиг

Б.Мөнхдалай

С.Энхтүвшин